



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/40

Д.УА-2018/424/СТА-ТШЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эрдэнэдалай сумын Биеийн тамир, спортын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн сангаас “Бага олимп болон гамшгаас хамгаалах сургуулилт”-д оролцсон албан хаагчид урамшуулал олгож зардлыг зориулалт бусаар зарцуулсан нийт 109,496.00 /нэг зуун есөн мянга дөрвөн зуун ерэн зургаан/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалын 6-р хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар” /Үндсэн цалин-цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалинг энэ ангилалд бүртгэнэ/ гэж заасныг тус тус зөрчсөн;

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төл бөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, дотоод хяналтыг сайжруулах;

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 02 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Биеийн тамир, спортын төвийн төсвийн шууд захирагч Г.Пүрэв, нягтлан бодогч Д.Ууганбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР  Г.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

МЕНЕЖЕР  Г.ПҮРЭВ

НЯГТЛАН БОДОГЧ  Д.УУГАНБАЯР

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.